



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/118/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: П.Чанцалдулам  
Утас: 261740 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК-ийн  
Партнер: Н.Эрдэнэцог  
Утас: 70770744 Цахим хаяг: [erdenetsog.n@mn.gt.com](mailto:erdenetsog.n@mn.gt.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14
8.1 Төлбөрийн акт .....	14
8.2 Албан шаардлага .....	15
8.3 Зөвлөмж .....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16
10. Хавсралт: Төлбөрийн акт, албан шаардлага .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЗК	Тусгай зориулалтын компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦК	Үнэт цаасны компани
ОНОСХШТ	Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл
ЭХОНОСС	Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.МӨНХБАТ ТАНАА

2022.03.15 № 07/630  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан 2017 оны “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдааны дүн 392.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг зөрчсөн, санхүүгийн ухаалаг удирдлагыг хэрэгжүүлээгүй буюу санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, авлагыг төлөгдөх боломжтой дүнгээр бүртгээгүй буюу СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-н дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

## **Асуудлыг онцолсон зүйл**

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын баталсан 2017 оны “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу бэлтгэж, толилуулсан.

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх энэхүү заавар нь СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд аж ахуйн нэгж байгууллагууд дотооддоо СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж ажиллахыг шаарддаг боловч СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй.

Мөн аудит хийсэн санхүүгийн тайлан нь Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт шаардсан бүрэн хэмжээний тодруулгыг хавсаргаагүй болно.

## **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд байдлаар авч үзсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний 155 дугаар тогтоолоор тус компанийн үйл ажиллагааг татан буулгахаар шийдвэрлэсэн боловч Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор татан буулгах үйл ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Уг шийдвэртэй холбогдуулж Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 2021 оны 4-р улирлын үйл ажиллагааны зардал 155.7 сая төгрөгийг төсөвлөснөөс 102.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Хөрөнгө</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,962,048,335.66	10,077,796,463.80
1.1.2	Дансны авлага	346,164,518.08	0.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	9,598,554.63	14,375,886.16
1.1.4	Бусад авлага	3,468,709,971.34	1,211,496,281.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,000,000,000.00	0.00
1.1.6	Бараа материал	0.00	90,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,786,521,379.71</b>	<b>11,303,758,630.96</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	149,871,940.47	121,071,738.86
1.2.2	Биет бус хөрөнгө	8,090,270.30	4,287,640.55
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>157,962,210.77</b>	<b>125,359,379.41</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,944,483,590.48</b>	<b>11,429,118,010.37</b>
2.1.1.1	Дансны өглөг	1,889,818,849.29	1,797,478,651.04
2.1.1.2	Цалингийн өглөг	2,075,848.39	0.00
2.1.1.3	Татварын өр	16,117,611.00	4,188,054.87
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,652,000.00	0.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,909,664,308.68</b>	<b>1,801,666,705.91</b>
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,909,664,308.68</b>	<b>1,801,666,705.91</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>10,000,000,000.00</b>	<b>10,000,000,000.00</b>
2.3.1	Төрийн	10,000,000,000.00	10,000,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	34,819,281.80	(372,548,695.54)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>10,034,819,281.80</b>	<b>9,627,451,304.46</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,944,483,590.48</b>	<b>11,429,118,010.37</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	346,164,518.08	0.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>346,164,518.08</b>	<b>0.00</b>
5	Хүүгийн орлого	1,172,045,895.12	268,833,852.01
8	Бусад орлого	19,401,814.13	75,276,348.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,616,479,569.13	722,397,878.45
12	Бусад зардал	14,579,021.21	2,196,914.04
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(93,446,363.01)</b>	<b>(380,484,592.12)</b>
19	Орлогын татварын зардал	240,395,093.36	26,883,385.22
<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(333,841,456.37)</b>	<b>(407,367,977.34)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(333,841,456.37)</b>	<b>(407,367,977.34)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>(333,841,456.37)</b>	<b>(407,367,977.34)</b>



### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,000,000,000.00</b>	<b>368,660,738.17</b>	<b>10,368,660,738.17</b>
3	Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00	368,660,738.17	10,368,660,738.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(333,841,456.37)	(333,841,456.37)
9	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,000,000,000.00</b>	<b>34,819,281.80</b>	<b>10,034,819,281.80</b>
11	Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00	34,819,281.80	10,034,819,281.80
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(407,367,977.34)	(407,367,977.34)
17	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>10,000,000,000.00</b>	<b>(372,548,695.54)</b>	<b>9,627,451,304.46</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,207,175,041.77</b>	<b>8,417,130,126.29</b>
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	346,164,518.08
1.1.4	Буцаан авсан албан татвар	70,012,278.28	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,116,601,211.01	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	20,561,552.48	8,070,965,608.21
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,717,341,779.34</b>	<b>7,062,263,362.07</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,116,342,681.86	436,940,671.24
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	213,707,387.38	130,144,806.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	15,434,483.00	1,181,304.88
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	141,170,793.03	141,017,756.04
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,287,800.00	3,040,115.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	149,465,026.96	60,408,237.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,688,840.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,074,933,607.11	6,287,841,630.70
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,510,166,737.57)</b>	<b>1,354,866,764.22</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>3,163,749,600.50</b>	<b>6,765,844,866.17</b>
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	76,346,896.87	765,854,866.17
2.1.8	Бусад	3,087,402,703.63	5,999,990,000.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>34,063,892.48</b>	<b>4,523,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	4,523,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,454,250.00	0.00
2.2.6	Бусад	27,609,642.48	0.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,129,685,708.02</b>	<b>6,761,321,866.17</b>
<b>3</b>	<b>Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>43,354,188.26</b>	<b>(440,502.25)</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,662,873,158.71</b>	<b>8,115,748,128.14</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>299,175,176.95</b>	<b>1,962,048,335.66</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,962,048,335.66</b>	<b>10,077,796,463.80</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад удирдлагын тогтолцоог сайжруулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Грант Торнтон аудит ХХК-ийн аудитын багийн хянан удирдагч (партнер) Н.Эрдэнэцог, ахлагч аудитор (партнер) Б.Дэлгэрмаа, аудитор Л.Болорцэцэг, аудитор С.Уянга нар тус тус хэрэгжүүлсэн.

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 3/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсэн.

Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор компанийг татан буулгах ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх болсонтой холбогдуулан санхүүгийн тайланг бэлтгэх тасралтгүй үйл ажиллагааны зарчим баримтлан ажиллах болсон. Компанийн үйл ажиллагаа 2021 онд сэргэж эхэлсэн бөгөөд ТУЗ болон дотоод хяналтын нэгж нь томилогдоогүй байна. Иймээс дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна гэж үзсэн.

Компанийн татан буугдах ажиллагааг зогсоож үйл ажиллагааг сэргээсэнтэй холбогдуулан компанийн үйл ажиллагааны журмууд өөрчлөгдөж, шинэчлэн батлагдаж байна.

Компанийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 24-ний 37/18 тоот тогтоолоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж, мөрдсөн байна.

2021 оны 10 сард Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн дотоод аудитын албанаас компанийг татан буулгах комиссын үйл ажиллагаанд аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн санхүүгийн тайлангийн талаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг судлах аудитын горим хэрэгжүүлснээр Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан 2017 оны “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулсан гэж үзсэн.

Тус Компани нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, Сангийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46-р тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам”-ын дагуу санхүүгийн тайлангаа улсын хэмжээнд нэгтгүүлэх үүднээс санхүүгийн тайлангийн и-баланс системд цахим хэлбэрээр хүргүүлдэг тусгай зорилго бүхий, үнэн зөв толилуулгын зарчмын дагуу бэлтгэсэн, энэхүү тайланг ашиглах хэрэглэгчийн хувьд хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 11,429.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 114.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК нь 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдөр хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 241 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын удирдлагын үйл ажиллагаа эрхлэх 360/16 тоот тусгай зөвшөөрөл авсан байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай бөгөөд 100.0 хувь Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн эзэмшилд байна.

Монгол Улсын Засгийн Газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл” (ОНОСХШТ)-ийн хүрээнд “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан”(ЭХОНОСС)-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх компани бөгөөд санг үүсгэн байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

## 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үйл ажиллагааг сэргээж татан буулгах тогтоолын заалтыг хүчингүй болгосон байна. Тус шийдвэрийг үндэслэн Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Компанийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Хөгжлийн банкны Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэхээр баталсан байна.

Уг тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 дүгээр шийдвэрээр компанийн үйл ажиллагааг сэргээх тухай шийдвэрийг гаргасан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар шийдвэрээр компанийн шинэчилсэн дүрэм болон бүтцийг баталжээ.

Мөн “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 241 дүгээр тогтоолын дагуу хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр Монгол Улсын стратегийн ач холбогдолтой, нийгэм эдийн засгийн үр ашигтай, урт хугацааны төслүүдэд хөрөнгө оруулах, төслийн хөгжүүлэлтийг санхүүжүүлэх, Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эрсдэлийг бууруулах зорилго бүхий Үндэсний стратегийн хөрөнгө оруулалтын санг хувийн хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Уг шийдвэрийн хэрэгжилттэй холбогдуулан тус компани нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.14 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2 дугаар зүйлд тус тус заасны дагуу “Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 539 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн байна.

Тайлант хугацаанд Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Компанийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын бэлтгэсэн холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэгдсэн байна.

Компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 515.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,962,048.3	10,077,796.5	8,115,748.1
Дансны авлага	346,164.5	-	(346,164.5)
Татвар, НДШ – ийн авлага	9,598.6	14,375.9	4,777.3
Бусад авлага	3,468,710.0	1,211,496.3	(2,257,213.7)
Бусад санхүүгийн хөрөнгө	6,000,000.0	-	(6,000,000.0)
Бараа материал	-	90.0	90.0
Үндсэн хөрөнгө	149,871.9	121,071.7	(28,800.2)
Биет бус хөрөнгө	8,090.3	4,287.6	(3,802.6)

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,944,484.6</b>	<b>11,429,120.0</b>	<b>(515,364.6)</b>
Дансны өглөг	1,889,818.8	1,797,478.7	(92,340.2)
Цалингийн өглөг	2,075.8	-	(2,075.8)
Татварын өр	16,117.6	4,188.1	(11,929.6)
НДШ - ийн өглөг	1,652.0	-	(1,652.0)
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,909,664.3</b>	<b>1,801,666.7</b>	<b>(107,997.6)</b>
Төрийн	10,000,000.0	10,000,000.0	-
Хуримтлагдсан ашиг	34,819.3	(372,548.7)	(407,368.0)
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>10,034,819.3</b>	<b>9,627,451.3</b>	<b>(407,368.0)</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,944,483.6</b>	<b>11,429,118.0</b>	<b>(515,365.6)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, санхүүгийн түрээсийн авлага, урт хугацаат хөрөнгө оруулалт, бусад эргэлтийн бус хөрөнгө өр төлбөрийн дансад дараах материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Тайлант хугацаанд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хувьд оны эхэнд 1,962.0 сая төгрөг байснаас жилийн эцэст 10,077.8 сая төгрөг болж өссөн бөгөөд хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дуусахаас гадна авлагын дансанд бүртгэлтэй байсан 8,000.0 сая төгрөг МУХБ-д байрших “Ди Би Эм Ассетс менежмент ҮЦК” ХХК-ийн мөнгөн хөрөнгөнд шилжсэн.
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхэнд 9.6 сая төгрөг байснаас оны эцэст 14.4 сая төгрөг болсон нь 2021 оны 5 дугаар сард нэмэгдсэн өртгийн албан татварын төлөгч болж 4.5 сая төгрөгийн НӨАТ-ын авлага үүссэн.
- Дансны авлагын хувьд 346.2 сая төгрөгөөр буурсан. Энэ нь 2020 оны менежментийн үйлчилгээний орлого “Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт хувийн ХОС ТЗК” ХХК-аас 2021 оны эхэнд орж ирсэн.
- Бусад авлагын хувьд оны эхэнд 3,468.7 сая төгрөг байснаас 1,211.5 сая төгрөг болж буурсан нь Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас авах авлагаар бүртгэсэн байсан 1,800.0 сая төгрөгийг мөнгөн хөрөнгөөр бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө нийтдээ оны эхэнд 158.0 сая төгрөг байснаас 2021 оны 11 дүгээр сард худалдан авсан 4.1 сая төгрөгийн зөөврийн компьютерын дүнгээр нэмэгдэж, тухайн жилийн элэгдлийн 36.7 сая төгрөгөөр буурсан.
- Дансны өглөг 1,889.8 сая төгрөг байснаас жилийн эцэст 1,797.5 сая төгрөг болсон нь 9.4 сая төгрөгийн өглөг төлөгдөж, 7.6 сая төгрөгийн өглөгийг бусад орлогоор бүртгэсэн.
- Татварын өр нь оны эхэнд 16.1 сая төгрөг байснаас жилийн эцэст 4.2 сая төгрөг болж буурсан. Энэ нь 4-р улирлын ХХОАТ болон суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын өглөг.
- Компанийн шинэчлэгдсэн дүрмээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг бүр нь 200,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байгаа бөгөөд нийт үнийн дүн 10,000.0 сая төгрөг байна.
- Өмнөх оны хуримтлагдсан ашиг 34.8 сая төгрөг байснаас тайлант жилийн алдагдлын дүн болох 407.4 сая төгрөгөөр буурч, хуримтлагдсан алдагдал 372.5 сая төгрөг болсон.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Компани үйл ажиллагаагаа сэргээхтэй холбогдож Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 04 дүгээр тушаалаар “Ди Би Эм Ассет Менежмент



ҮЦК” ХХК-ийн 2021 оны 10-12 саруудын үйл ажиллагааны зардал 155.7 сая төгрөгийг төсөвлөснөөс 102.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 11 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” нь тайлант онд нийт 11 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 73.9 сая төгрөгийн нийт 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйл 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах зөвлөмж өгөх.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Гроут финанс Аудит” ХХК гүйцэтгэсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2021 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Монгол Улсын Засгийн Газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл”-өөс Компанийн хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдон гарах зардлуудын үр ашигтай, зохистой эсэхийг дараа жилийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

## **8. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 392.0 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 159.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 60.6 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 172.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 392.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 114.3 сая төгрөгийн түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **8.1 Төлбөрийн акт**

Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн Банкны Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг 2020 онд татан буулгах шийдвэр гарч, 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилсон ба үүнээс 7 хүнийг МУХБ-наас давхар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаснаар

Азийн Хөгжлийн Банктай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөх эрсдэл үүссэнийг Хувьцаа эзэмшигч цаг тухайд нь шийдээгүйгээс компанийг татан буулгах комиссын үйл ажиллагаа удааширч, МУХБ-наас ажилласан ажилтнуудад 2021 онд 159.3 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг илүү тооцон олгож үр ашиггүй зардал гаргасан зөрчилд буцаан төлүүлэх акт тогтоох.

## 8.2 Албан шаардлага

Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК нь Ти Би групп ХХК-ийн "Down Town" оффисын барилгын нийт 264.28 м.кв (нэг ажилтанд 17.62 м.кв талбай) талбайг оффисын зориулалтаар түрээслэхдээ Засгийн газрын 120 дугаар тогтоолоор баталсан нэг ажилтанд ногдох жишгээс 9.62 мв-аар илүү талбай түрээсэлж, тайлант онд 60.6 сая төгрөгөөр илүү зардал гаргасан нь Засгийн газрын “Зардлын норматив, нийтлэг жишиг” батлах тухай 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг” болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын байрны тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн түрээсийн зардал гаргасан зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

## 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Авлага, өр төлбөрийн талаар*

### Илрүүлэлт:

“Чингис хаан банк” ХХК-тай 2018, 2019 онуудад байгуулсан хадгаламжийн гэрээний дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,128.6 сая төгрөгийн хадгаламж, хүүгийн авлага бүртгэлтэй байна. Тус компани нь “Чингис хаан банк” ХХК-д холбогдуулан хадгаламжийн гэрээний үүргээ биелүүлэхийг шаардаж шүүхэд нэхэмжлэл гаргасан. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрээр “Чингис хаан банк” ХХК-аас 956.6 сая төгрөгийг гаргуулах, нэхэмжлэгч “Ди Би Эм Ассет менежмент” ХХК-д өгөх шийдвэр гарсан байна. Компани уг харилцагчаас авах авлагын төлөгдөх боломжтой дүнг бодитоор үнэлж бүртгээгүй, 172.0 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

Энэ нь СТОУС 9 “Авлагыг цэвэр боломжит үнэ цэнэ буюу төлөгдөх боломжтой дүнгээр толилуулна” гэснийг, мөн Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.1.2. "Компани нь найдваргүй авлагын нөөц байгуулах, авлагыг данснаас хасахдаа СТОУС, компанийн удирдлагын шийдвэр, удирдлагаас баталсан тусгайлсан бодлого, журмыг баримтална", "тухайн жилийн найдваргүй авлагын нөөц байгуулах саналыг Нягтлан бодогч боловсруулж “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу найдваргүй авлагын нөөцийг байгуулах зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж				
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																	
1	Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/118/НА-СТА-ТӨА	“Чингис хаан банк” ХХК-тай 2018, 2019 онуудад байгуулсан хадгаламжийн гэрээний дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,128.6 сая төгрөгийн хадгаламж, хүүгийн авлага бүртгэлтэй байна. Тус компани нь “Чингис хаан банк” ХХК-д холбогдуулан хадгаламжийн гэрээний үүргээ биелүүлэхийг шаардаж шүүхэд нэхэмжлэл гаргасан. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрээр Чингис хаан банк ХХК-аас 956.6 сая төгрөгийг гаргуулах, нэхэмжлэгч Ди Би Эм Ассет менежмент ХХК-д өгөх шийдвэр гарсан байна. Компани уг харилцагчаас авах авлагын төлөгдөх боломжтой дүнг бодитоор үнэлж бүртгээгүй, 172.0 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.	СТОУС болон НББ-н бодлогын баримт бичгийн дагуу найдваргүй авлагын нөөцийг байгуулах зөвлөмж өгөх	1	172,054.4										1	172,054.4
2	Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/118/НА-СТА-ТӨА	Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн Банкны Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг 2020 онд татан буулгах шийдвэр гарч, 14 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг томилсон ба үүнээс 7 хүнийг МУХБ-наас давхар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаснаар АХБ-тай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөх эрсдэл үүссэнийг Хувьцаа эзэмшигч цаг тухайд нь шийдээгүйгээс компанийг татан буулгах комиссын үйл ажиллагаа удааширч, МУХБ-наас ажилласан ажилтнуудад 2021 онд 159.3 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.	Цалин давхардуулан олгож үр ашиггүй зардал гаргасан зөрчилд буцаан төлүүлэх акт тогтоох	1	159,300.0			1	159,300.0							

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
3	Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/118/НА-СТА-ТӨА	Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК нь Ти Би групп ХХК-ийн "Down Town" оффисын барилгын нийт 264.28 м.кв (нэг ажилтанд 17.62 м.кв талбай) талбайг оффисын зориулалтаар түрээслэхдээ Засгийн газрын 120 дугаар тогтоолоор баталсан нэг ажилтанд ногдох жишгээс 9.62 мв-аар илүү талбай түрээсэлж, тайлант онд 60.6 сая төгрөгөөр илүү зардал гаргасан байна.	Ажлын байрны тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн түрээсийн зардал гаргасан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	60,597.6							1	60,597.6		
	<b>дүн</b>				3	391,952.0			1	159,300.0	1	60,597.6	1	172,054.4		
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																
1	Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	АХГ-2022/118/НА-СТА-ТӨА	“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК нь тайлант онд нийт 11 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 73.9 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх	1	73,919.3									1	73,919.3
	<b>дүн</b>				1	73,919.3									1	73,919.3
	<b>Нийт</b>				4	465,871.3			1	159,300.0	1	60,597.6	2	245,973.7		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 138/20150053

Улаанбаатар хот

АХГ-2022/18/МА СТА Т9А

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн Банкны Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг 2020 онд татан буулгах шийдвэр гарч, 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилсон ба үүнээс 7 хүнийг МУХБ-наас давхар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаснаар Азийн Хөгжлийн Банктай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөх эрсдэл үүссэнийг Хувьцаа эзэмшигч цаг тухайд нь шийдээгүйгээс компанийг татан буулгах комиссын үйл ажиллагаа удааширч, МУХБ-наас ажилласан ажилтнуудад 2021 онд 159,300,000.00 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон цалин 159,300,000.00 (Нэг зуун тавин есөн сая гурван зуун мянган) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбат, нягтлан бодогч С.Алтантуяа нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
АУДИТОР

Б. Дамсралаа



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ӨНХДАЛАЙ

Б.ОСОРГАРАВ  
Б.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага талдуу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
9019120396

\\10.10.10.3\ichig\_khereg\Akt\2022\0325 Auditin 2 Газар-90.Docx

0001090376



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 648/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/118/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК нь Ти Би групп ХХК-ийн "Down Town" оффисын барилгын нийт 264.28 м.кв (нэг ажилтанд 17.62 м.кв талбай) талбайг оффисын зориулалтаар түрээслэхдээ Засгийн газрын 120 дугаар тогтоолоор баталсан нэг ажилтанд ногдох жишгээс 9.62 мв-аар илүү талбай түрээсэлж, тайлант онд 60,597,600.00 төгрөгөөр илүү зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын "Зардлын норматив, нийтлэг жишиг" батлах тухай 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг" болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашиглай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлын байрны тогтоосон нормоос илүү талбай түрээсэлсэн зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбат, нягтлан бодогч С.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХҮЖИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Б.ОСОРГАРАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
9019120396  
\\10.10.10.20\Bichig\_Khureg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-408.Docx

0001001040

